



**НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот


Г “Нийслэлийн өмчийн концессын зүйлийн  
жагсаалт”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Концессын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 20/20 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д оруулах нэмэлт өөрчлөлтийг хавсралт ёсоор баталсугай.

2.“Нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг Концессын тухай хууль, Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолоор баталсан “Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам”-ын дагуу зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Р.ДАГВА

1110100345

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны 06 дугаар сарын  
25-ны өдрийн 109 дүгээр тогтоолын хавсралт

**"НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ЖАГСААЛТ"-Д  
НЭМЭЛТЭЭР ОРУУЛЖ БУЙ ТӨСӨЛ**

№	№	Концессын зүйлийн нэр	Концессын зүйлийн тодорхойлолт	Концессын зүйлийн төрөл	Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ	Төсвийн хөрөнгөөр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах эсэх	Уралдаант шалгаруулалт явуулах/Шууд гэрээ байгуулах эсэх	Тайлбар
1	1	2	3	4	5	6	7	8
<b>Дэд бүтцийн болон бусад салбар</b>								
1	1	Хог хаягдал дахин боловсруулах төсөл	Концесс эзэмшигч нь өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр Улаанбаатар хотын төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг дахин боловсруулж дулаан болон цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр барьж, концессын гэрээнд заасан нөхцөлөөр ашиглан нийслэлийн өмчид шилжүүлнэ. Эсвэл зураг төсвийг боловсруулан, барьж, концессын гэрээнд заасан нөхцөлөөр өмчилж, ашиглана.	Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх, Зураг төсөл боловсруулах-барих-өмчлөх-ашиглах	Концесс эзэмшигч нь төвлөрсөн хогийн цэгийн хог хаягдлыг шатааж, эрчим хүч үйлдвэрлэн, цахилгаан, дулааны сүлжээнд нийлүүлэх, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба түүхий эд-хог хаягдлаар тасралтгүй хангах үүрэг хүлээнэ.	үгүй	Уралдаант шалгаруулалт явуулах	
2	2	Нийтийн ахуйн үйлчилгээний төв төсөл	Концесс эзэмшигч нь өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр Улаанбаатар хотын гэр хороололд шаардлагатай байршилд Нийтийн ахуйн үйлчилгээний барьж, концессын гэрээнд заасан нөхцөлөөр ашиглан нийслэлийн өмчид шилжүүлнэ. Эсвэл зураг төсвийг боловсруулан, барьж, концессын гэрээнд заасан нөхцөлөөр өмчилж, ашиглана.	Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх, Зураг төсөл боловсруулах-барих-өмчлөх-ашиглах	Концесс эзэмшигч Нийтийн ахуйн үйлчилгээний төвийн барилгыг барьж, үйлчилгээ үзүүлнэ.	үгүй	Уралдаант шалгаруулалт явуулах	